

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН (Эхний хагас жил)

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)		
0	1	2	3	4	5	6	
ЗОРИЛГО. УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /"Алсын хараа-2050" зорилт 5.3, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.3, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2008 оны стратеги төлөвлөгөө							
Зорилт 1.Инновацийг дэмжигч, илтгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.							
1	Арга хэмжээ-1.1. Тоон гарын үсэг олголтыг болон түүний хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	1.Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо, хувь 2. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээний тоо	1.2024 онд ... буюу 91.3 хувь	100	1.Тоон гарын үсгийн олголтын талаар: 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 10-ны хооронд тоон гарын үсгийн олголт киоск машинаас гар утасанд 1025, иргэний үнэмлэхэнд 1293, нийт 2318 тоон гарын үсэг олгогдсон, харин улсын бүртгэгчээс гар утсанд 3654, иргэний үнэмлэхэнд 34, нийт 3688 олгогдсон байна. Өөрөөр хэлбэл, киоск машин болон улсын бүртгэгчээс нийт 6006 тоон гарын үсэг олгогдсон байна. Харин нэгжээс 2024 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын		
			2.2024 онд 18 удаа	10			

					12-ныг өдрийг дуулах хугацаанд 6956 тоон гарын үсэг олгогдсон байна. 2.Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр -Иргэдийн Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, тоон гарын үсэг ашиглан төрийн цахим үйлчилгээ авах, цахим ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга зүйн сургалтыг 2025 оны 02 дугаар сараас эхлэн 5 удаагийн сургалтыг зохион байгууллаа. -Тоон гарын үсгийн хэрэглээг Цахим үндэстэн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилтой уялдуулан "Цахим элч-цахим сургагч багш" нарыг бэлтгэх, тэд нараар дамжуулан тоон гарын хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг идэвхижүүлэх өсвөр үеийн 200, ахмадын 45, хөгжлийн бэрхшээлтэй 18 иргэнтэй "Хурдан-24/7" клубыг аймгийн Засаг даргын дэргэдэх клуб болгон өргөжүүлэн байгуулж, "Баянхонгор Хурдан-24/7" клуб фэйж хуудастай болов.	50 хувь
2	Арга хэмжээ-1.2. Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх	Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн байна	1	2 удаа	1.Иргэний улсын бүртгэлийн Гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээг 2025 оны 3 дугаар сарын 31-нд хийж хэлтсийн даргад танилцуулан, улмаар улсын бүртгэлийн үйл ажиллагаанд учирч буй доголдол, хийдлийг арилгах замаар сумдад гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Тодруулбал, 20 сумын улсын бүртгэгчид тус бүртгэлийн эрхийг нээлгүүлж, дадлагыг хийлгэж, бүртгэл хөтлөх үйл ажиллагааг эхлүүлсэн болно. 2.Дараагийн өгөгдлийн шинжилгээг 3,4-р улиралд хийхээр төлөвлөсөн болно.	

3	Арга хэмжээ-1.3. Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах асуудлын хүрээнд үйлчлүүлэгчдийн дунд санал асуулга авах	Хэрэглэгчийн сэтгэл ханамж, хүсч буй зорилгыг таньж мэдэж, дүн шинжилгээ хийж УБЕГ-т тайлагнах	1 /цаасан хэлбэрээр авсан/	1 /цахим болон цаасан хэлбэрээр/ авна.	2025 оны 4-р улиралд хийхээр төлөвлөсөн бөгөөд хугацаа болоогүй.	-
4	Арга хэмжээ-1.4. Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу иргэдийн хаягийн өөрчлөлтийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд тулган шалгах, цахим санд бүртгэхтэй холбоотойгоор шаардлагатай мэдээллийг боловсруулж ИУБГ-т танилцуулах	Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу иргэдийн хаяг шинэчлэгдсэн хувь	20% /2022 он/	100 % хүргэх	1.Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу шилжсэн үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг шинэ, хуучин хаягаар нь тулган шалгах ажлыг багийн бүртгэлийн ажилтнуудтай хамтран багийн хилийн цэсийн зураг дээр тэмдэглэгдсэн хаягийг хаягжуулалттай холбоотойгоор гарсан аймгийн ИТХ-ын 2016 оны 42, 2018 оны 42 дугаарт тогтоолтой тулган нягтлах ажлыг хийв. 2.Хаяг тулгасны дараа ИУБГ-т хэлтсийн даргын дугаарт албан бичгээр хилийн цэсийн дагуу шилжсэн гудамжны хуучин хаяг бүрээс иргэн бүртгэлтэй хаяг тус бүрийг жагсаалтаар гаргаж ирүүлэх хүсэлтийг тавьж, улмаар хаягийн жагсаалтыг файлаар болон албан бичгийн хамт хүлээн авч, баг, гудамжаар нь улсын бүртгэгч нарт хуваарилан өгч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд шалгуулаад байна. 3.Улсын бүртгэгч нарын шалгасан хаягийг дахин нягтлан шалгах ажлыг 6 сардаа багтаан эхлүүлэхээр төлөвлөж байна.	30 хувь
5	Арга хэмжээ-1.5. Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй иргэний хаягийг хүн бүрээр тулган шалгаж, иргэний	1.Судалгаа гаргасан тоо 2.Илэрсэн зөрчлийг арилгасан тоо,	-	1.Хөдөөгийн 19 сум бүрээр судалгаа гарна 2. 20 хувь зөрчлийг	Хөдөөгийн 19 сум бүрээр судалгааг гаргуулах ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	10 хувь

	байнга оршин суугаа хаягийн бүртгэлийн зөрчилтэй иргэдийн судалгааг баг бүрээр гаргаж, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах	хувь		арилгасан байна.		
6	Арга хэмжээ-1.6. Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх	Улсын бүртгэлийн киоск машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо	4500	5000	Киоск машинаас гар утсанд 1025, иргэний үнэмлэхэнд 1293, нийт 2318 тоон гарын үсэг олгогдсон байна. Мөн улсын бүртгэлийн киоск машинаас иргэний улсын бүртгэлийн 1964 лавлагаа олгогдсон байна.	85.64 хувь
7	Арга хэмжээ-1.7. Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинэчлэн боловсруулах шаардлагатай хуудь, дүрэм, журмын төсөлд санал хүргүүлэх	Эрх зүйн актын төсөлд санал хүргүүлсэн тоо	4-5	4-5	Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хэлэлцүүлэгт (төсөлд) 7 санлыг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр battsengel@burtgel.gov.mn хаягаар, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, иргэний улсын бүртгэл хөтлөх журамд нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд тус тус 13 санлыг 2025 оны 03 дугаар сарын 16-ны өдөр bologmaa.p@burtgel.gov.mn хаягаар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 9 санлыг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр g.munkhgerel@burtgel.gov.mn хаягаар тус тус хүргүүлсэн байна.	100 хувь
Зорилт 2. Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн шуурхай байдлыг нэмэгдүүлэх						
8	Арга хэмжээ-2.1. Иргэний улсын бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлөх	Бүртгэлийн үйлчилгээ авах хүсэлтийг шийдвэрлэсэн тоо, хувь	100 хувь	100 хувь	Тайлант хугацаанд буюу 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 25-ны хооронд иргэний улсын бүртгэлийн 6268 бүртгэл бүртгэгдсэн байна. Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ авах хүсэлттэй холбоотойгоор "Бүртгэхээс татгалзаж	100 хувь

					шийдвэрлэсэн бүртгэл” байхгүй байна.	
9	Арга хэмжээ-2.2. Иргэний улсын мэдээлэл, лавлагаа өгөх	бүртгэлийн	Хүсэлтийг шийдвэрлэсэн хувь	100 хувь	100 хувь	
10	Арга хэмжээ-2.3. Төрийн цахим үйлчилгээний портал /E-mongolia/ иргэний бүртгэлийн үйлчилгээ авах тоог нэмэгдүүлэх		Цахимаар үзүүлсэн иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний тоо			100 хувь
11	Арга хэмжээ-2.4. Иргэний улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх тоог нэмэгдүүлэх		1.Үзүүлсэн үйлчилгээний тоо 2. Зорилтод бүлэгт үзүүлсэн үйлчилгээний тоо			1.Алслагдсан сум, багийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээ: Жинст, Богд сумын иргэдэд үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ, иргэний улсын бүртгэлийн хууль, журам зөрчсөн иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлж, бүртгэлийн үйлчилгээний “нэг цэг”-ийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулж, 102 иргэнд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ. 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр Бөмбөгөр сум, 4 дүгээр сарын ... Баянхонгор сумын Шаргалжуут 8 багт тус тус явуулын үйлчилгээ үзүүлж, 53 бүртгэл хийсэн байна. 2.Зорилтод бүлэгт үзүүлсэн үйлчилгээ: -Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй 35 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байх ба үүнээс өндөр настай хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнд 4G төхөөрөмжөөр

					явуулын үйлчилгээг гэрээр нь, очиж, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, бичиг баримттай болгов. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс гадна хэвтрийн дэглэмтэй, эмнэлэгт хүүхдээ харан хэвтэж буй ээжүүд, өндөр настай ахмадууд зэрэг зорилтод бүлгийн иргэдэд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл 16, иргэний бүртгэлийн лавлагаа 8, төрсний бүртгэл, төрсний гэрчилгээ олголт 3, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 7, иргэний үнэмлэхний дахин 3, иргэний үнэмлэх олголт 1, овог нэр өөрчлөлтийн бүртгэл 1, эцэг тогтоолтын бүртгэл 2, гэрлэсний бүртгэл 2, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 1, тоон гарын үсэг олголт 44, гадаад паспортын бүртгэл 2, нийт 90 бүртгэл хийсэн байна.	100 хувь
12	Арга хэмжээ-2.5. Цахим гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлдэг болгох ажлыг зохион байгуулах	1.Тус бүртгэлийн үйлчилгээг 20 сумдад шилжүүлэх 2. Сумдад үзүүлсэн бүртгэлийн үйчилгээний тоо	--	1.20 сум 2.Бүртгэл тоо	Гадаад паспортын бүртгэл хийх дадлагын удирдамжийг боловсруулан Хэлтсийн даргаар батлуулан, удирдамжинд заасан хуваарийн дагуу 2025 оны 03 сард эхний 8 сумын улсын бүртгэгчдийг, 2025 оны 05 сард үлдсэн 11 сумын улсын бүртгэгчдийг гадаад паспортын бүртгэл хийлгүүлсэн бөгөөд өнөөдөр 20 сумын улсын бүртгэгчид бүгд бүртгэл хийж байна. Гадаад паспортын бүртгэлийн эрх олгогдсоноор 2025 оны 03 дугаар сараас 2025 оны 06 дугаар сарын 10-ныг хүртэлх хугацаанд хөдөө суманд гадаад паспортын 302 бүртгэл бүртгэгдээд байна.	
Зорилт 3.Иргэний улсын бүртгэл болон иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах						
13	Арга хэмжээ-3.1. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн мэдээллийн алдаа, зөрчлийг арилгах	Бүртгэлийн зөрчил арилгуулахаар иргэдээс ирүүлсэн	87,7	100	-Тайлант хугацаанд буюу 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 12-ныг хүртэлх хугацаанд улсын ахлах бүртгэгчээс нөхөн бүртгэл 85, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 239,	

		өргөдлийг шийдвэрлэсэн хувь			нийт 324 бүртгэл хийгдсэн байна. Нөхөн бүртгэлийг бүртгэлийн төрлөөр ангилвал; төрсний бүртгэл 41, гэрлэсний бүртгэл 40, үрчилсний бүртгэл 1, нас барсны бүртгэл 1, харин нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг бүртгэлийн төрлөөр илэрхийлвэл; төрсний бүртгэл 110, үрчилсний бүртгэл 15, гэрлэсний бүртгэл 2, нас барсны бүртгэл 6, үндсэн сангийн нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 106 байна. -Хяналтын улсын ахлах байцаагчийн 2023/004865 дугаарт дүгнэлтийг үндэслэн төрсний бүртгэлд ургийн овог ороогүй, эцэг /эх/ тогтоосны бүртгэлд ургийн овог ороогүй, төрсний бүртгэлд эцэг эхийн мэдээлэл ороогүй зэрэг 92 бүртгэлийн зөрчлийг арилгаж цахим санд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг бүртгэв. -Хяналтын улсын ахлах байцаагчийн 2023/001543 дугаарт дүгнэлтийг үндэслэн 46 бүртгэлийн зөрчлийг арилгасан байна. -Мөн регистрийн дугаар буруу олгогдсон, төрсөн он, сар, өдөр буруу бүртгэгдсэн, бүртгэлийн мэдээлэл буруу орсон гэх мэт зөрчилтэй холбогдуулан хяналтын улсын байцаагчийн 27 дүгнэлт гаргуулан, гарсан дүгнэлтийг үндэслэн бүртгэлд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг бүртгэсэн байна. - иргэний үнэмлэхний бүртгэлтэй /иргэний үнэмлэхээ авсан/ боловч нэрийн санд "тодорхойгүй" төлөвтэй 17 иргэний төлөвийг нэрийн санд засав.	70 хувь
14	Арга хэмжээ-3.2. Иргэний улсын бүртгэлийн сангаас 2023-2025 онуудад олгосон лавлагааны бүртгэлд хяналт	Шалгасан бүртгэлийн тоо, хувь	-	100	2025 оны 2, 3-р улиралд хийхээр төлөвлөсөн бөгөөд хугацаа болоогүй.	--

шалгалт хийх Арга хэмжээ-3.3. Иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдлийг бууруулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	1.Зөвлөмж хүргүүлсэн тоо 2. Сургалт болон нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо	4	- Улсын бүртгэгч нарыг улс төрийн дарамт, ажлын байрны дарамтаас урьдчилан сэргийлэх болон улс төрийн нөлөөлөөс хамгаалах, мөн дарамт шахалтын улмаас буруу бүртгэл хийх эрсдлээс хамгаалах зорилгоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үр дүнд шинээр сонгогдсон сумын ИТХ-ын дарга, шинээр томилогдсон Засаг дарга нарт хандан улсын бүртгэгч нарт дарамт шахалт үзүүлэхгүй байх, улсын бүртгэгч нарт хуулиар олгогдсон эрх үүргээс давсан хууль бус мэдээллийг шаардахгүй байх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлж, хуулийн дагуу хамтран ажиллахыг сануулсан зөвлөмж, мэдэгдлийг хэлтсийн даргын гарын үсэгтэй албан бичгээр хүргүүлэв. - Баянхонгор аймгийн сумдын бүх багуудад багийн иргэдийн нийтийн хурал хуралдах, багийн Иргэдийн нийтийн хурлын дарга, Засаг дарга нарыг сонгох сонгуульт ажил явагдаж байгаатай холбоотойгоор сумаас сумд, багаас багт шилжсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбогдуулан хууль тогтоомжийн үзэл санаа, зорилгыг зөв ойлгож, бүртгэх, эс бүртгэх шийдвэр гаргахдаа Захиргааны ерөнхий хуулийн 24, 25, 26, 27 дугаар зүйлд заасан хуулийн хэм хэмжээг хуулийн хүрээнд зөв хэрэглэж шийдвэрээ гаргахыг анхааруулж, эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллахыг чиглэл болгосон албан бичгээр 2 удаа чиглэл, хяналтын улсын байцаагчтай хамтран арга зүйн сургалтыг 2 удаа, хэлтсийн ажилтнуудын хаалттай facebook группээр 2 удаагийн
--	--	----------	--

17	Арга хэмжээ-4.1. Архивын улсын үзлэгт ажлыг зохион байгуулах	1.Иргэний баримтын архивын хадгалалтын байнгын болон түр баримтын нэгж бүрийг байршуулсан тоо, хувь 2.Баримтын хаягжуулалтыг цэгцлэж, шинэчилсэн тоо, хувь	-	100 хувь	1.Архивын улсын үзлэгт бэлтгэх бэлтгэл ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн санд байршаагүй маягтыг байршуулах, бүртгэлийг бүрэн хөтлөх зорилгоор "Иргэний улсын бүртгэлийн маягтыг хувийн хэрэгт байршуулах ажлыг зохион байгуулах тухай" Хэлтсийн даргын 2025 оны дугаарт тушаалаар ажлын хэсэг байгуулан 5172 ширхэг маягтыг нэр бүхий санд байршуулах ажлыг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэж, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр бүрэн дуусгав. 2.Баримтын хаягжуулалтыг цэгцлэх, шинэчилэх ажлыг эхлүүлээд байна.	60 хувь
18	Улсын бүртгэлийн нэгжид хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах	Хийсэн бүртгэлийн тоогоор иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулсан хувь	... бүртгэл бүртгэгдсэнээр 24623 хуудас цахимжуулсан 100 хувь	Нийт бүртгэгдсэн бүртгэлийн тоо, 100 хувь цахимжих	Тайлант хугацаанд буюу 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 25-ны хооронд иргэний улсын бүртгэлийн 6268 бүртгэл бүртгэгдсэнээр 9649 хуудас маягт нотлох баримт цахимжуулсан байна. Иргэний улсын бүртгэлийн нөхөн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл хийлгүүлэхээр ирүүлсэн 252 өргөдөл, хүсэлтээс өнөөдрийн байдлаар 215 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн өргөдөлтэй холбоотойгоор төрсний, гэрлэсний, үрчилсний бүртгэлийн 183 хуудас нотлох баримт, маягтыг "Мэдээлэл лавлах" системд цахимжуулсан байна. Өргөдөлтэй холбоотой нэмэлт өөрчлөлт, нөхөн бүртгэл хийсэн бүртгэлийн тоог арга хэмжээ 3.1-д давхар тайлагнасан болно. Үлдсэн 37 өргөдөл хуулийн хугацаандаа шийдвэрлэгдэхээр хянагдаж байна.	100 хувь

19	Иргэний улсын бүртгэлийн Мэдээлэл лавлах системд цахимжаагүй үлдсэн Баянхонгор сумын 2011-2021 оны, Шинэжинст сумын 2015-2021 оны төрсний бүртгэл-ХААТР-11, үрчилсний бүртгэл-ХААТР-12, эцэг /эх/ тогтоосны бүртгэл-ХААТР-14 маягтыг цахимжуулах	Эх нотлох баримтыг цахимжуулсан хувь	88.8 хувь	100	2025 оны 02 дугаар сардаа багтаан үлдсэн Баянхонгор сумын 2014-2021 оны, Шинэжинст сумын 2015-2021 оны маягтуудыг бүрэн цахимжуулж дуусгав.	100 хувь
20	Иргэний улсын бүртгэлийн Мэдээлэл лавлах системд цахимжаагүй 1963-1998 оны гэрлэлтийн бүртгэл ХААТР-15 маягтыг цахимжуулах	Цахимжуулсан хувь	-	100	2025 оны 3, 4-р улиралд хийхээр төлөвлөсөн бөгөөд хугацаа болоогүй.	-
Зорилт 5. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх						
21	Арга хэмжээ-5.1. УБЕГ болон хэлтсээс зохион байгуулж буй танхим, цахим сургалтанд иргэний улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	1.Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдалтын хувь	23 100	23 100	1.Иргэний улсын бүртгэлийн газраас зохион АТГ болон Нийслэлийн Прокурорын газартай хамтран зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтанд иргэний улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулав., 2.Хэлтсээс зохион байгуулсан хүний хөгжил, байгууллагын соёл, уур амьсгал, харилцаа хандлагын чиглэлээр Насан туршийн суралцахуйн төвийн багш нарыг урьж оролцуулсан 4 удаагийн сургалтанд; 3.Төрийн албан хаагчийн ёс зүй, авилгаас ангид байх, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, ёс зүйн соёл, зөв хандлагыг өөртөө болон өөрийн хүрээлэлдээ төлөвшүүлэх, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 5 удаагийн сургалтанд; 4.Хэлтсээс 2025 оны 05 сард зохион байгуулсан Улсын бүртгэгч нарын нэгдсэн сургалтанд тус тус бүрэн хамруулав.	100 хувь

22	Арга хэмжээ-5.2. Иргэний улсын бүртгэгч нарын хууль хэрэглэж, эрх зүйн дүгнэлт өгөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах	1.Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдалтын хувь	23 100	23 улсын бүртгэгч 4 удаагийн сургалт 100 хувь хамрагдалт	Улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхамаас 1.“Улсын бүртгэлийн эрсдлийг тооцох, эрсдлээс урьдчилан сэргийлэх” сэдвийн хүрээнд өмнө нь гарч байсан бүртгэлийн алдаа, түүнээс үүссэн үр дагавар, одоо үүсч болох эрсдлийг кейс жишээн дээр тайлбарласан сургалт, 2.“Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл, түүний эрх зүйн зохицуулалт” сэдвийн хүрээнд иргэний гэрлэлтийн бүртгэл, үрчлэлтийн бүртгэлээс үүсэх хууль зүйн үр дагаварыг кейс, жишээ дээр тайлбарласан сургалт тус тус зохион байгууллаав.	50 хувь
23	Арга хэмжээ-5.3. Иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдлийг үнэлэх, эрсдлээс сэргийлэх арга барил эзэмших чадавхийг сайжруулахад чиглэсэн сургалт зохион байгуулах, эрсдлийн үнэлгээ хийх, төлөвлөгөө гаргах	1.Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдалтын хувь	2 удаагийн сургалт 100 хувь хамрагдаж байсан	100	1.“Улсын бүртгэлийн эрсдлийг тооцох, эрсдлээс урьдчилан сэргийлэх” сэдвийн хүрээнд бүртгэл хөтлөхөд гарч болох эрсдлийн үнэлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх арга барил эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтыг улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам зохион байгуулав. 2.Иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаатай холбоотойгоор ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдлийг үнэлэх, эрсдлийн төлөвлөгөө гаргах ажлын хэсгийг байгуулан, бэлтгэл ажлыг хангаж байна.	40 хувь
24	Арга хэмжээ-5.4. Улсын бүртгэгч нарт гадаад паспорт авах, зураг засвар хийх аргачилсан сургалт зохион байгуулах, дадлага хийлгэх	1.Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдалтын хувь	20 100	20 100	Гадаад паспортын бүртгэл хийх дадлагын удирдамжийг боловсруулан Хэлтсийн даргаар батлуулан, удирдамжинд заасан хуваарийн дагуу 2025 оны 03 сард эхний 8 сумын улсын бүртгэгчдийг, 2025 оны 05 сард үлдсэн 11 сумын улсын бүртгэгчдийг гадаад паспортын бүртгэл хийлгүүлсэн бөгөөд өнөөдөр 20 сумын улсын бүртгэгчид бүгд бүртгэл хийж байна.	100 хувь
25	Арга хэмжээ-5.5. Улсын бүртгэгч нарын мэдлэг, ур	Сорилго, сорилтод		15 албан хаагч	2025 оны 3, 4-р улиралд хийхээр төлөвлөсөн бөгөөд хугацаа болоогүй.	-

	чадвар, чадамжийг зорилгоор түүвэрчилсэн сорилго, сорилт авах	дээшлүүлэх аргаар	хамрагдсан албан хаагчийн тоо	-	хамрагдсан байна.		
26	Арга хэмжээ-5.6. Улсын бүртгэгч нарын мэргэжлийн ур чадварын уралдаан зохион байгуулах		Уралдаан зохион байгуулагдсан байна.	-	1 удаа	2025 оны 3-р улиралд хийхээр төлөвлөсөн бөгөөд хугацаа болоогүй.	-
Зорилт 6. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнана.							
27	Арга хэмжээ-6.1. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих		1.Ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо 2.Шийдвэрлэлт ийн тоо, хувь	87.7	100	Иргэний улсын бүртгэлийн нөхөн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл хийлгүүлэхээр ирүүлсэн 252 өргөдөл, хүсэлтээс өнөөдрийн байдлаар 215 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн өргөдөлтэй холбоотойгоор төрсний, гэрлэсний, үрчилсний бүртгэлийн 183 хуудас нотлох баримт , маягтыг "Мэдээлэл лавлах" системд цахимжуулсан байна.	Тайлант хугацаанд иүүлсэн өргөдлийн шийдвэрлэлт 85.3 хувь
28	Арга хэмжээ-6.2. УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмж, хугацаатай бүртгэл хөтөлж, хэрэгжилтийг хангаж ажиллах	чиглэл, үүрэг хөтөлж, хэрэгжилтийг хангаж ажиллах	Үүрэг, даалгаврын хэрэгжилтийн хувь	100	100	1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн төлөвлөгөө, цаглабарын дагуу ИУБГ-аас ирүүлсэн 4,5 удаагийн чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг ханган, тухай бүрт нь илтгэх хуудсаар тайлагнаж ажиллаав. 2.ИУБГ-аас 02 сард ирүүлсэн Иргэний үнэмлэхний бүртгэл шалгах хугацаатай даалгаврын дагуу бүртгэлийг шалгаж, авсан арга хэмжээний талаар тайланг Илтгэх хуудсаар тайлагнав. 3.УБЕГ-аас улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж буй төлөвлөгөө, төсөл хөтөлбөрт санал авахаар ирүүлсэн үүрэг даалгаврын дагуу "Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2025 оны төлөвлөгөөний төсөл,	100 хувь

						түүний 8 дахь арга хэмжээний шалгуур үзүүлэлт" зэрэгт 5 санал, "Байгууллагын цаасны хэрэглээг бууруулах" талаар 12 саналыг нэгтгэн хүргүүлсэн байна.		
29	Арга хэмжээ-6.3. Иргэний улсын бүртгэлийн мэдээ, тайлан, мэдээллийг холбогдох нэгж, хүнд хүргүүлэх	Хүргүүлсэн тоо	12	12		Иргэний улсын бүртгэлийн тоон мэдээ /эхний 5 сарын/ ИУБГ-т, харин иргэний улсын бүртгэлийн лавлагааны бүртгэлийн мэдээ Бүртгэлийн нэгдсэн архивын төвд тус тус сар бүр хуулийн хугацаандаа хүргэгдээд байна.	50 хувь	
30	Арга хэмжээ-6.4. Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлан таниулах нийтэд түгээх ажлыг зохион байгуулах	1.Сурталчилсан хэвлэлийн мэдээллийн хэрэгслийн тоо 2. Олон нийтэд сурталчилсан мэдээ, мэдээллийн тоо 3.Контентын тоо	3 5 	3 15 10		1.Хууль эрх, зүйн хэлтсийн урилгаар Эрх зүйн хөтөч нарт "Хуулийн этгээдийн хэлбэр, түүний эрх зүйн зохицуулалт" сэдвээр сургалт оров. 2."Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл, түүний эрх зүйн зохицуулалт" сэдвийн хүрээнд гэрлэлт, гэрлэлт дуусгавар болох, үрчлэлтийн бүртгэл, түүнээс үүсэх үр дагаврын талаар сургалт мэдээлэл өгөх, мэдлэг олгох сургалтыг 2025 оны 04 сард Нотариатын танхимын нотариатчтай хамтран зохион байгуулав. 3.Гадаад паспортын бүртгэл, иргэний улсын бүртгэлийн тоон мэдээ, сумдад нэвтрүүлсэн бүртгэлийн нэр төрөл зэрэг 4 контент бэлтгэн түгээсэн байна. 4.Хүрээмарал, Баянбулаг, Бууцаган, Бөмбөгөр сумдад улсын бүртгэлийн цахим шилжилт, цахим хэрэглээг сурталчилж таниулсан мэдээллийг өгөв	0 30 хувь	
31	Арга хэмжээ-6.5. Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, хууль тогтоомж сурталчлах "Нээлттэй хаалганы" өдөрлөг зохион байгуулах	"Нээлттэй хаалганы" өдөрлөг зохион байгуулсан тоо		3		1."Нээлттэй хаалганы өдөрлөг" арга хэмжээг зохион байгуулах тухай" аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 13 дугаарт удирдамжийн дагуу оролцож, 5 иргэнд тоон гарын үсэг олгох, 1 иргэнд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ. 2."Хууль, сурталчлах, зөвлөн туслах, сургалт нөлөөлөл"-ийн арга хэмжээ		

					зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 32 дугаарт удирдамжийн дагуу аймгийн хуулийн байгууллага (Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Прокурорын газар, Шүүх шинжилгээний газар, гэх мэт)-уудтай хамтран оролцож, Баянбулаг, Хүрээмарал, Бууцагаан, Бөмбөгөр суманд ажиллав. 3. “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 13 дугаарт удирдамжийн дагуу оролцож, 5 иргэнд тоон гарын үсэг олгох, 1 иргэнд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ. 4.Жинст, Богд суманд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулав:	100 хувь
32	Арга хэмжээ-6.6. Аймаг, сумын ИТХ, Засаг дарга, төрийн байгууллагууд, хууль хяналтын байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх	1.Санал тавьж шийдвэрлүүлсэн тоо 2. Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо	1 3 /ХААН банк, Эрүүл мэндийн газар, Цахим үйлчилгээний хэлтэс, Нотариатын танхим, Баянхонгор сумын ЗДТГ, Насан туршийн суралцахын алба/	2 7 /ЭМГ, Нэгдсэ эмнэлэг, ХААН, Төрийн банк, Цахим үйлчилгээний хэлтэс, ГХУСАЗЗ, Насан ругшийн суралцахуйн алба, Нотаритын танхим, Шүүх/	1.Тоон гарын үсгийн олголт программ болон сүлжээний саатлаас шалтгаалан асуудал үүсэх бүрт ХААН, Төрийн банкинд 2 удаагийн албан бичгээр мэдэгдэл хүргүүлж, иргэдэд хүндрэл, чирэгдэлгүйгээр үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэв. 2.Нас барсан хүүхдүүдээ улсын бүртгэлд нөхөн бүртгүүлэх боломжгүй болсон ээжүүдэд туслах үүднээс аймгийн Иргэний хэргийн анхан шатны сум дундын шүүхийн шүүгч нартай уулзаж, Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх боломжтой кейс тохиолдолуудыг ярилцаж, шүүхэд нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэх талаар зөвшилд хүрч, хэргийг шийдвэрлэхээр тогтов. 3.Аймгийн нотариатын танхимтай	100 хувь


					хамтран гэр бүлийн эрх зүйнс ургалтыг олон нийтэд зохион байгуулав. 4.Хууль эрх, зүйн хэлтсийн урилгаар Эрх зүйн хөтөч нарт сургалт оров. 5.Аймгийн ахмадын холбоо, Баянхонгор сумын ахмадын хороо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо, Тэргэнцэртэй иргэдийн холбоо, Хараагүй иргэдийн холбоо зэрэг олон нийтийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг сайжруулах, тоон гарын үсгийн хэрэглээний чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн сургалтыг 2025 оны 5 сард "Цахим элч-цахим сургагч багш" хүүхдүүдийн оролцоотойгоор зохион байгуулав.				
33	Арга хэмжээ-6.7. Иргэний улсын бүртгэлийн цахим үйлчилгээг сурталчлах "Сургагч багш" бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх	Сургагч багш бэлтгэсэн тоо	24	150	Ийнхүү өсвөр үеийн 200 хүүхэд, ахмад 45, хөгжлийн бэрхшээлтэй 18 иргэдийн бүрэлдэхүүнтэй бүлгэмийг бий болж, улмаар тогтвортой, байнгын үйл ажиллагаатай клубыг байгуулж, иргэдийн цахим ур чадварыг сайжруулах зорилтод арга хэмжээтэй уялдуулан аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран өсвөр үеийн, ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Хурдан-24/7" клубыг аймгийн Засаг даргын дэргэдэх клубын зохион байгуулалттайгаар байгуулав. Өсвөр үеийн 200 хүүхэд, ахмадын 45, хөгжлийн бэрхшээлтэй 18 иргэдийг клубын гишүүнээр элсүүлж, төрийн цахим үйлчилгээг авах арга зүйн сургалтуудыг зохион байгуулж, цахим ур чадварыг нэмэгдүүлэв.	100 хувь			

Зорилт 7. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Зорилт 7. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.

34	Арга хэмжээ-7.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжилт сонгуулиар /Дахин сонгуультай холбогдуулан/ улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх зээлээр заасан чиг үүргийг ханган ажиллах ажлын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэх	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх зээлээр заасан чиг үүргийг ханган ажиллах ажлын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэх	100	100	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөө, цаглабарын дагуу цаг үеийн ажлыг чанартай гүйцэтгэхийн зэрэгцээ "Цахим системд оруулсан орон нутгийн нөхөн сонгуулийн Сонгогчдын нэрийн жагсаалтыг шалгасан тухай", Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсоосонтой холбоотойгоор сонгуулийн программд хэсэг оноолт хийж, шалгасан талаар", "Сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчид төлөв оноосон мэдээллийг шалгасан тухай" "Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэж, хүлээлгэн өгсөн тухай" зэрэг 4 удаагийн илтгэх хуудсаар ажлыг тайлагнаад байна.	80 хувь
Зорилт 8. Тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ						
35	Арга хэмжээ-8.1. Монгол бичиг сурах	Монгол бичиг уншиж, бичиж сурсан байна.	30	100	"Монгол бичгийн толь бичиг" номыг худалдан авч даан судлаж байна.	20 хувь
36	Арга хэмжээ-8.2 Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана.	Суралцсан кредит цаг	Төрийн удирдлага, Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлагаар Мэргэшүүлэх дипломын сургалтанд хамрагдсан. 2016 оны төгсөгч	Суралцаж төгссөн байна.	Хугацаа болоогүй	
37	УБЕГ-ын болон хэлтсийн дотоод сургалтанд хамрагдана.	Сургалтанд бүрэн хамрагдсан байна.		Сургалтанд бүрэн хамрагдсан байна.	ИУБГ-ын АТГ-тай хамтран зохион байгуулсан 2 удаагийн онлайн сургалтанд, УБЕГ дээр зохион байгуулсан чадавхжуулах сургалтанд 1 удаа хамрагдсан. Хэлтсийн дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан 12 удаагийн сургалтанд бүрэн хамрагдав.	100 хувь

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТАСГИЙН ДАРГА,
УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ


Н. БУЖИНДЖАМ

Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч
(албан тушаалын нэр)
ПҮРЭВДАГВЫН БҮЖИНЛХАМЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

Нэгжийн нэр: Иргэний улсын бүртгэлийн тасаг

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/ д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн , ил тод нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна..... хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 1.1.	60	10	70	
2.	Арга хэмжээ 1.2.	-	-	-	
3.	Арга хэмжээ 1.3.	-	-	-	
4.	Арга хэмжээ 1.4.	18	10	28	
5.	Арга хэмжээ 1.5.	0	0	0	
6.	Арга хэмжээ 1.6.	51,3	10	61,3	
7.	Арга хэмжээ 1.7.	60	10	70	
Зорилт 2.-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 2.1.	60	10	70	
2.	Арга хэмжээ 2.2.	60	10	70	
3.	Арга хэмжээ 2.3.	30	10	40	
4.	Арга хэмжээ 2.4.	60	10	70	
5.	Арга хэмжээ 2.5.	60	10	70	
Зорилт 3.-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 3.1.	42	5	47	
2.	Арга хэмжээ 3.2.	-	-	-	
3.	Арга хэмжээ 3.3.	60	10	70	
4.	Арга хэмжээ 3.4.	60	10	70	
Зорилт 4.-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1	Арга хэмжээ 4.1	30	10	40	
2	Арга хэмжээ 4.2.	60	10	70	
3	Арга хэмжээ 4.3.	60	10	70	
4	Арга хэмжээ 4.4.	-	-	-	
Зорилт 5.-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 5.1.	48	10	58	
2	Арга хэмжээ 5.2.	30	10	40	
3	Арга хэмжээ 5.3.	24	10	34	
4	Арга хэмжээ 5.4.	60	10	70	
5	Арга хэмжээ 5.5.	-	-	-	

6	Арга хэмжээ 5.6.	-	-	-	
Зорилт 6-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1	Арга хэмжээ 6.1.	51,18	10	61,18	
2	Арга хэмжээ 6.2.	42	10	52	
3	Арга хэмжээ 6.3.	60	10	70	
4	Арга хэмжээ 6.4.	18	10	28	
5	Арга хэмжээ 6.5.	60	10	70	
6	Арга хэмжээ 6.6	60	10	70	
7	Арга хэмжээ 6.7	60	10	70	
Зорилт 7-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1	Арга хэмжээ 7.1	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.					
Дундаж оноо:				57,4	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/ д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээн ий багийн хянан баталгаа жуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1.	70	10,5	
2	Арга хэмжээ 2.	-	-	
3	Арга хэмжээ 3.	80	12	
Дундаж оноо			11,25	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/ д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	5	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	5	
5.	Ажлын цаг ашиглалт	4	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		5,4	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/ д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	6,1
2.	Багаар ажиллах	6,09
3.	Харилцаа	6,1
Дундаж оноо		6,1

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(57,4 оноо)
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(11,25 оноо)
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(5,4 оноо)
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(6,1 оноо)
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		80,15

Үнэлгээ өгсөн:

...*Маттеин*...*сарт*...
(албан тушаал)

Нэгжийн дарга

.....
(гарын үсэг)

Шонхтөрөл!
(албан хаагчийн нэр)

(02H00)

Үнэлгээтэй танилцаж,

зөвшөөрсөн:

Улест ахлах бүртгэл
(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:

(гарын үсэг)

1. Пётр Хану
(албан хаагчийн нэр)

(02H00)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Хяналтын үүсэл (албан тушаал) 6853009 (гарын үсэг)

(гарын үсэг) 

1. Л. Манушян
(албан хаагчийн нэр)

2008-03-19
(02H00)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

.....
(албан тушаал)

Г.А. Дор
.....
(гарын үсэг)

.....
(албан хаагчийн нэр)
.....
(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Намгийн гэрл
.....
(албан тушаал)

М.М. Мухоморов
.....
(гарын үсэг)

М.М. Мухоморов
.....
(албан хаагчийн нэр)
..... (огноо)

